



МОНГОЛ УЛС
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
АЛБАН ДААЛГАВАР

2023 оны 02 сарын 20 өдөр

Дугаар 03

Чингис хот

Насан туршийн боловсролын
үйл ажиллагааг дэмжих тухай

Монгол Улсын Боловсролын тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.1.2, 30.1.16, Монгол хэлний тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.3 дахь заалт, Засгийн газрын 96 дугаар тогтоолыг тус тус үндэслэн **ДААЛГАХ** нь:

Бүх насны иргэдэд үндсэн чиглэлийн сургалтыг тасралтгүй эзэмшүүлэх, хөгжлийн ялгаатай хүүхдүүдэд боловсрол нөхөн олгох зорилгоор боловсролын үйл ажиллагааг тогтолжуулж дараах ажлыг хийж гүйцэтгэхийг сумын Засаг дарга нарт даалгасугай.

1. Насан туршийн боловсролын сумын багш нарын үйл ажиллагааг удирдан чиглүүлж, төсөл хөтөлбөрт хамруулан, санхүүгийн бодит дэмжлэг үзүүлж, үндсэн чиглэлийн сургалтыг иргэдийн эрэлт хэрэгцээнд тулгуурлан явуулахад хамтарч ажиллах;
2. Насан туршийн боловсролын сумдын багшийн ажлыг сумдын "Иргэний танхим-болон бусад танхимиын үйл ажиллагаатай уялдуулан багийн өдөрлөг уулзалт, сургалт зохион байгуулах үеэр багшийг заавал оролцуулж, явуулын сургалт зохион байгуулах нөхцөл боломжоор хангах;
3. Сумын бичиг үсэггүй иргэдийн судалгааг Насан туршийн боловсролын багш, багийн Засаг дарга нараар гаргуулан бичиг үсгийн боловсрол олгох сургалтыг зохих хугацаа, төлөвлөлтийн дагуу явуулж бичиг үсэгт тайлах сургалтыг зохион байгуулсан байх;
4. Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2018 оны 46 дугаар зарлиг, Монгол бичгийн үндэсний хөтөлбөр-III-ийг хэрэгжүүлж эхэлсэнтэй холбогдуулан нийт төрийн албан хаагчдад Монгол бичгийн хичээлийг тусгай хөтөлбөрийн дагуу зааж, Монгол бичгийн мэдлэг сайжруулах ажлыг зохион байгуулах;
5. Боловсролын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3 дахь заалтыг хэрэгжүүлэх зорилгоор суурь боловсрол эзэмшээгүй 45 хуртэлх насны иргэдийн бүртгэл

2.

судалгааг гарган “Боловсрол нөхөн олгох хөтөлбөрийн” дагуу сургалтад хамруулан суурь боловсрол эзэмшүүлэх;

6. Хүнд хэлбэрийн болон хэвтрийн хөгжлийн бэрхшээлтэй сургуулийн өмнөх боловсрол, сургуулийн насны суралцагчдад зориулсан гэрээр айлчлах сургалтыг хэрэгжүүлэхэд насан туршийн багшийг удирдлага зохион байгуулалтаар хангаж, дэмжлэг үзүүлэх;

7. Зохион байгуулсан ажил, арга хэмжээний үр дүнг 2023 оны 10-дугаар сарын 31-ний дотор Насан туршийн боловсролын төвд тайлагнахыг Сумын Засаг дарга нарт, тайлан мэдээг нэгтгэн Нийгмийн бодлогын хэлтэст хүргүүлж ажиллахыг Насан туршийн боловсролын төвийн захирал (Г.Дашдаваа)-д, албан даалгаврын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Нийгмийн бодлогын хэлтсийн дарга (Д.Өнөрцэцэг)-д тус тус үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА

Ц.ЧОГСОМЖАВ

